



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 02 дугаар  
сарын 23 ны өдөр

Дугаар ХЭГ/375

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Х.НЯМБААТАР,  
Т.АЮУРСАЙХАН, Л.ОЮУН-ЭРДЭНЭ,  
Ж.ЭНХБАЯР, Л.ЭНХБОЛД НАР ТАНАА

Асуултын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 51 хувийг баталгаанд гаргаж, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Стандарт банкнаас авсан зээл, түүнтэй холбоотой олон улсын шүүхийн байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилттэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуултын хариуг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

 Т.ЗАНДАНШАТАР

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ГИШҮҮН Х.НЯМБААТАР, Т.АЮУРСАЙХАН, Л.ОЮУН-ЭРДЭНЭ,  
Ж.ЭНХБАЯР, Л.ЭНХБОЛД НАРААС ТАВЬСАН АСУУЛТЫН ХАРИУ**

**Нэг.** "Жаст групп" ХХК-ийн Өмнөд Африкийн Стандарт банкнаас авсан нийт зээлийн хэмжээний талаар

2009-2010 онд "Жаст групп" ХХК-ийн Өмнөд Африкийн Стандарт банк (цаашид "Стандарт банк" гэх)-аас авсан зээлийн нийт хэмжээг Лондонгийн Олон улсын Арбитрын шүүх дээр үүссэн арбитрын хэрэгт авагдсан нотлох баримтуудад тулгуурлан гаргавал:

-2009 оны 7 дугаар сарын 8-ны өдөр "Жаст групп" ХХК нь Стандарт банктай 36,000,000 ам.долларын "Зээлийн гэрээ" байгуулсан бөгөөд 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр "Нэмэлт гэрээ" байгуулан зээлийн хэмжээг 75,000,000 ам.доллар болгож нэмэгдүүлсэн;

-2010 оны 8 дугаар сарын 5-ны өдөр "Жаст групп" ХХК нь Стандарт банктай дахин 27,000,000 ам.долларын "Зээлийн гэрээ" байгуулсан бөгөөд 2011 оны 12 дугаар сарын 20-ны өдөр "Нэмэлт гэрээ" байгуулан зээлийн хэмжээг 34,000,000 ам.доллар болгож нэмэгдүүлсэн.

Дээрхийг нэгтгэвэл, 2009-2010 онд "Жаст групп" ХХК Стандарт банкнаас нийт 109,000,000 ам.долларын зээл авсан байна.

**Хоёр.** Зээл авсан үйл ажиллагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх талаар

Зээл авсан үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх асуудлыг Авлигатай тэмцэх газар шалгаж байгаа бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа хараахан дуусаагүй байна.

**Гурав.** Баталгаа гаргасан холбогдох албан тушаалтнууд хууль зүйн хувьд эрхтэй байсан эсэх талаар

Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1-д "Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгэйгээр гаргана" гэж заасан. "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн дүрэмд зааснаар компанийн гүйцэтгэх удирдлага нь 10,000,000 сая хүртэлх ам.долларын хэлцэлд компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр төлөөлөх эрхтэй бөгөөд түүнээс дээшх үнийн дүнтэй хэлцэлд оролцох эрхгүй юм.

Гэтэл "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн удирдлагаас зөвшөөрөл өгөөгүй байхад "Жаст групп" ХХК хуурамч баримт бичиг бүрдүүлж зээл авсан талаар тухайн үеийн "Эрдэнэт үйлдвэр" ХХК болон Төрийн өмчийн хорооны удирдлагууд мэдүүлжээ.

Энэ асуудлаар иргэн Ш.Батхүү нарт холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтсээс 2013 онд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа бөгөөд 2015 оноос Авлигатай тэмцэх газар шалгаж байна.

Лондонгийн Олон улсын Арбитрын шүүхээс "Жаст групп" ХХК болон Стандарт банк хооронд байгуулсан 2009, 2010 оны Үндсэн зээлийн гэрээнүүдэд "Эрдэнэт үйлдвэр" ХХК оролцсон байдлыг дараах байдлаар үндэслэлүүдийг дурьдсан байна. Үүнд:

2009 оны Үндсэн зээлийн гэрээний талаар гаргасан шийдвэрт:

-Стандарт банк нь "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн дагаж мөрддөг хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд гэрээнд оролцох чадамжтай байсан;  
-"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганзориг тухайн гэрээнүүдэд гарын үсэг зурах эрх мэдэлтэй байсан.

2010 оны Үндсэн зээлийн гэрээний талаар гаргасан шийдвэрт:

-Тус зээлийн гэрээнээс "Эрдэнэт үйлдвэр" ХХК ашиг хүртэх боломжтой байсан;

-Тус зээлийн гэрээнд холбогдох урьдач нөхцөл бүхий баримт бичигт Г.Амарбат, Ч.Ганзориг нар гарын үсэг зурсан;

-Тус зээлийн гэрээтэй холбоотой барьцаа гэрээний эрх шилжүүлэх тухай мэдэгдлийг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-аас дамжуулснаар эрх шилжүүлэлт хүчин төгөлдөр болсон;

-Тус зээлийн гэрээтэй холбоотой санхүүгийн баримт бичгүүдэд "Жаст групп" ХХК-ийн захирал Л.Бадамцэцэгийн цуглуулсан гарын үсгүүд байсан;

-"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганзоригийн өгсөн үүргийн дагуу Г.Амарбат, Б.Мөнхжаргал, Г.Галбаатар нар гэрээнд оролцсон нь тогтоогдсон гэж дурьдсан байна.

**Дөрөв.** Өмнөд Африкийн Стандарт банкнаас олгосон зээл "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн дансанд орсон эсэх, түүнийг хэрхэн зарцуулсан талаар

Эрдэнэт үйлдвэр ХХК-аас ирүүлсэн мэдээллээс авч үзвэл 2010-2013 онуудад Стандарт банкнаас нийт 213,3 сая ам долларын орлогын гүйлгээ Эрдэнэт үйлдвэрийн холбогдох дансанд орж ирсэн байна. Энэхүү орж ирсэн мөнгө нь Меркентал хаус, Миллфорд Глобал корпорациас төлөгдсөн борлуулалтын орлого гэж бүртгэгджээ. Уг орлогоос УБТЗ ХНН-д тээврийн хөлсний төлбөрт 55,6 сая ам доллар, Жаст компаниас нийлүүлсэн түлш, шатахууны төлбөрт 41,2 сая ам.доллар зэрэг төлбөрт Эрдэнэт үйлдвэр ХХК-аас шилжүүлсэн байна.

**Тав.** Зээлтэй холбогдуулан олон улсын шүүхийн байгууллагаас гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийн талаар

"Жаст групп" ХХК зээлээ хугацаанд нь төлөөгүйтэй холбогдуулан Стандарт банк нь 2013 оны 7 дугаар сард Лондонгийн Олон улсын Арбитрын шүүхэд хандан 109,000,000 ам.долларын зээлийн гэрээнд хамаарах 86,950,000 ам.долларыг баталгаа гаргасан гэсэн үндэслэлээр "Эрдэнэт үйлдвэр" ХХК-аас нэхэмжилсэн.

Лондонгийн Олон улсын Арбитрын шүүх 2016 оны 5 дугаар сард шүүх хуралдааныг явуулж, "Эрдэнэт үйлдвэр" ХХК нь "Жаст групп" ХХК-д баталгаа гаргасан гэж үзэж, 50,988,425.60 ам.долларын төлбөрийг Өмнөд Африкийн Стандарт банкинд төлүүлэхээр шийдвэрлэсэн. Уг шийдвэрийг эс зөвшөөрч, Английн Хатан хааны дэргэдэх Худалдааны дээд шүүхэд давж заалдах гомдол гаргах зөвшөөрлийг хүссэн боловч тус шүүх 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдөр шийдвэр гаргаж, 14 хоногийн дотор 50,988,425.60 ам.долларыг шүүхэд байршуулснаар давж заалдах зөвшөөрөл олгох нөхцөл заасан байна.

Тухайн үед дээрх нөхцөлийг биелүүлэх боломжгүй байсан тул "Эрдэнэт үйлдвэр" ХХК-аас Английн Давж заалдах шатны шүүхэд уг захирамжийг давах хүсэлт гаргасан боловч 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр гаргасан захирамжаар татгалзаж эцэслэн шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэр гарсны дараа Өмнөд Африкийн Стандарт банк нь үндсэн зээлийн хүү, шүүх ажиллагаанд зарцуулсан зардлаа гаргуулахаар Лондонгийн Олон улсын Арбитрын шүүхэд нэхэмжлэл гаргасныг 2017 оны 7 дугаар сарын 27-ны өдөр тус шүүх хэлэлцээд "Эрдэнэт үйлдвэр" ХХК-аас 14,438,164 ам.долларын зардал, 26,782,381 ам.долларын үндсэн зээлийн хүү, 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл тооцогдсон хүү 3,142,063 ам.доллар, нийт 44,362,608 ам.долларыг гаргуулан Стандарт банкинд олгохоор шийдвэрлэсэн. Уг хүү, зардалтай холбоотой маргаанд "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн зүгээс давж заалдсан бөгөөд хэргийн ажиллагаа үргэлжилж байна.

Түүнчлэн Стандарт банк нь 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Английн Худалдааны Дээд шүүхэд хандан "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн хөрөнгийг хураах, битүүмжлүүлэх талаар захирамж гаргуулах хүсэлт гаргасныг тус шүүх 2017 оны 11-р сарын 17-ны хуралдаанаар хэлэлцээд хүсэлтийг хангаж шийдвэрлэжээ.

Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар "Эрдэнэт үйлдвэр" ХХК-д холбогдох олон улсын арбитрын шүүхийн шийдвэртэй холбоотой асуудлаар мэдээллийг сонссон бөгөөд үндсэн зээлийн төлбөрийг тохирч барагдуулах, мөн хүүгийн нэмэлт төлбөрийг зогсоох асуудлаар Стандарт банктай нэн даруй хэлцэл хийхийг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгоод байна.

---ooOoo---

